

## ГЭРЭЭ

БАТЛАВ.

**ЗАХИАЛАГЧ:**  
**САНГИЙН ЯАМ**  
(Тамга, тэмдэг)



(Гарын үсэг)

**САНГИЙН САЙД**  
**Б.ЧОЙЖИЛСҮРЭН**

**ГҮЙЦЭТГЭГЧ:**  
**МОНГОЛЫН НИЯГТЛАН БОДОХ**  
**БҮРТГЭЛИЙН ХҮРЭЭЛЭН**  
(Тамга, тэмдэг)



(Гарын үсэг)

**МОНГОЛЫН НИЯГТЛАН БОДОХ**  
**БҮРТГЭЛИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН**  
**ТЭРГҮҮН Л.ДОНДОГ**

Нягтлан бодох бүртгэлийн төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах

Дугаар № СЯ 1609

Улаанбаатар хот

Нэг талаас Сангийн яам (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн(цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2016 оны 11 дугаар сарын 03 -ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

### ҮҮГЭЭР

- (а) Захиалагч үйлчилгээ үзүүлэгчээс энэ гэрээнд тусгагдсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд тодорхойлсон үйлчилгээг (цаашид “үйлчилгээ” гэх) үзүүлэхийг шаардсаны дагуу;
- (б) Үйлчилгээ үзүүлэгч нь энэ гэрээнд заасан нөхцөлийн дагуу гүйцэтгэхэд шаардлагатай мэргэжлийн ур чадвар, боловсон хүчин болон техникийн нөөц түүнд байгааг Захиалагчид илэрхийлсэний дагуу ;
- (в) Гэрээний үндсэн дээр ажлыг гүйцэтгэнэ.

Иймд талууд дараах зүйлсийг харилцан тохиролцов:

1. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болох бөгөөд гэрээнд хавсаргана. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- (а) Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- (б) Тендерт оролцогчийн тендер
- (в) Гэрээний ерөнхий нөхцөл;
- (г) Гэрээний тусгай нөхцөл;

Гэрээ нь энд дурдсан үйлчилгээг хийж гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно.

1. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
2. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан үйлчилгээг гүйцэтгэж, гэрээний явцад гарсан зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
3. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

Талууд энэхүү гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулмагц холбогдох этгээд гэрээг зөвшөөрч гарын үсэг зурсан өдрөөс эхлэн энэ гэрээ хүчин төгөлдөр болно.

Захиалагчийг төлөөлж:  
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА  
Б.ДОРЖСЭМБЭД



Үйлчилгээ үзүүлэгчийг төлөөлж:  
МОНГОЛЫН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ЕРӨНХИЙ  
МЕНЕЖЕР Х.ДЭЛГЭРСАЙХАН

\_\_\_\_\_

A handwritten signature in black ink, placed over a horizontal line.



## БҮЛЭГ 1. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

### 1. Ерөнхий заалт

#### 1.1 Нэр томьёо

Энэхүү гэрээнд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

- (a) “Үйл ажиллагааны хуваарь” гэж гүйцэтгэгчээс үзүүлэх бүх үйлчилгээний нэр төрлийг үнэлж тендерийн хамт ирүүлсэн жагсаалтыг хэлнэ;
- (б) “Үйлчилгээ дууссан өдөр” гэж гүйцэтгэгч үйлчилгээг гүйцэтгэж дууссаныг захиалагч гэрчилсэн өдрийг хэлнэ;
- (в) Гэрээ гэж захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулан гарын үсэг зурж энэхүү ерөнхий нөхцөл болон уг гэрээний 1 дэхь хэсэгт дурдсан баримт бичгүүдийг хавсаргасан гэрээг хэлнэ;
- (г) “Гэрээний үнэ” гэж энэ гэрээний 6 дугаар зүйлийн дагуу үйлчилгээний үр дүнд үндэслэн төлөх үнийг хэлнэ;
- (д) “Ажил-өдөр” гэж үйлчилгээ үзүүлэгчийн холбогдох удирдлагын болон материалын зардлаас гадна түүний ажиллах хүч болон тоног төхөөрөмжийн ажилласан хугацаанаас хамааран төлөгдөх төлөвлөөгүй зардлыг хэлнэ.
- (e) “Захиалагч” гэж үйлчилгээ үзүүлэгчийг хөлслөн ажиллуулж буй этгээдийг хэлнэ.
- (ё) “Гадаад валют” гэж төгрөгөөс өөр валютыг хэлнэ;
- (ж) “ГЕН” гэж эдгээр ерөнхий нөхцөлийг хэлнэ;
- (з) “Засгийн газар” гэж Монгол улсын Засгийн газрыг;
- (и) “Дотоодын валют” гэж төгрөгийг хэлнэ;
- (й) “Гишүүн” гэж үйлчилгээ үзүүлэх этгээд нь нэгээс олон байгууллагууд хамтран түншлэл болсон тохиолдолд түншлэлийн аливаа нэг байгууллагыг; “Гишүүд” гэж тэдгээр бүх байгууллагыг; “Төлөөлөх эрх бүхий гишүүн” гэж харин энэхүү гэрээний дагуу захиалагчийн өмнө үйлчилгээ үзүүлэгчийн хүлээх бүх эрх, үүрэг хариуцлагыг тэдний өмнөөс төлөөлөхөөр гэрээний тусгай нөхцөлд тодорхойлсон байгууллагыг;
- (к) “Тал” гэж Захиалагч эсхүл үйлчилгээ үзүүлэгч этгээдийг, харин “Талууд” гэж эдгээрийг хоёуланг нь ойлгоно;



- (л) “Боловсон хүчин” гэж тухайн үйлчилгээг эсхүл түүний зарим хэсгийн ажлыг гүйцэтгүүлэхээр үйлчилгээ үзүүлэгчийн эсхүл аливаа туслан гүйцэтгэгчийн томилон ажиллуулсан хүмүүсийг хэлнэ;
- (м) “Үйлчилгээ үзүүлэгч” гэдэг нь үйлчилгээ үзүүлэх тендерийг нь захиалагч хүлээн зөвшөөрсөн этгээдийг хэлнэ;
- (н) “Үйлчилгээ үзүүлэгчийн тендер” гэж Үйлчилгээ үзүүлэгчийн бэлтгэж Захиалагчид ирүүлсэн тендерийг хэлнэ;
- (о) “ГТН” гэж ГЕН-д нэмэлт өөрчлөлт оруулсан эсхүл тодотгосон энэ гэрээний тусгай нөхцөлийг хэлнэ;
- (е) “Үйлчилгээний үр дүнгийн тодорхойлолт” гэж Үйлчилгээ үзүүлэгчээс захиалагчид ирүүлсэн тендерийн бүрэлдэхүүнд багтсан үйлчилгээний тодорхойлолтыг хэлнэ;
- (р) “Үйлчилгээ” гэж Үйлчилгээ үзүүлэгчийн тендерт тусгасан үйлчилгээний тодорхойлолт, үйл ажиллагааны хуваарь болон гэрээний хавсралт А-д нийцүүлэн энэхүү гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэгчийн гүйцэтгэх ажлыг;
- (с) “Туслан гүйцэтгэгч” гэж 3.5 болон 4 дүгээр зүйлийн дагуу үйлчилгээний зарим хэсгийг туслан гүйцэтгүүлэхээр Үйлчилгээ үзүүлэгчийн гэрээ байгуулсан этгээдийг;

**1.2 Гэрээний хууль** Гэрээний тусгай нөхцөл(ГТН)-д өөрөөр тусгайлан заагаагүй бол энэхүү гэрээ нь Монгол улсын хуулиар зохицуулагдана.

**1.3 Гэрээний хэл** Энэ гэрээ нь ГТН-д тусгайлан заасан хэлээр бичигдэнэ. Энэ нь гэрээний агуулга, тайлбартай холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэхэд ашиглах хэл байна.

**1.4 Мэдэгдэл** Энэ гэрээний дагуу хийгдэх аливаа мэдэгдэл, хүсэлт, эсхүл зөвшөөрлийг бичгээр үйлдэж түүнийг харилцагч талын төлөөлөх эрх бүхий этгээдэд ГТН-д заасан хаягаар нь баталгаат шуудан, эсхүл факсаар хүргэгдсэн үед хийгдсэн гэж үзнэ.

**1.5 Байршил** Үйлчилгээ нь Хавсралт А, болон үйлчилгээний үр дүнгийн тодорхойлолтод заасан газар хийгдэх ба тодорхой ажлын байршил тусгайлан заагдаагүй бол захиалагчийн баталсан байршилд хийгдэнэ.



- 1.6 Төлөөлөх эрх бүхий этгээд** Энэ гэрээний дагуу захиалагч эсхүл үйлчилгээ үзүүлэгчийн хэрэгжүүлэх шаардлагатай буюу зөвшөөрөгдсөн аливаа арга хэмжээ болон боловсруулах шаардлагатай аливаа баримт бичгийг зөвхөн ГТН-д заасан албан тушаалтнууд гүйцэтгэж эсхүл боловсруулж болно.
- 1.7 Засгийн газрын хяналт шалгалт** Үйлчилгээ үзүүлэгч гэрээний санхүүжилтийг хариуцаж буй засгийн газрын холбогдох байгууллагын шаардсанаар үйлчилгээний хэрэгжилт, үр дүнтэй холбоотой аливаа бүртгэл, тайланг шалгуулах, түүний томилсон аудиторроор үр дүнгийн хяналт хийлгэхийг зөвшөөрөх үүрэгтэй.
- 1.8 Татвар хураамж** Үйлчилгээ үзүүлэгч, туслан гүйцэтгэгчид болон тэдний ажилтан холбогдох хууль, тогтоомжийн дагуу ногдох аливаа татвар, хураамжийг төлөх үүрэгтэй.

## 2. Гэрээг эхлэх, дуусгах, өөрчлөх болон цуцлах

- 2.1 Гэрээ хүчин төгөлдөр болох** Энэхүү гэрээ нь хоёр тал гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс эсхүл ГТН-д заасан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 2.2 Үйлчилгээг эхлүүлэх**
- 2.2.1 Хөтөлбөр** Үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн гүйцэтгэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө, зохион байгуулалт болон хугацааг харуулсан хөтөлбөр гаргаж батлуулан захиалагчид мэдэгдэнэ. Үйлчилгээ нь батлагдсан хөтөлбөр түүний тодотголын дагуу хийгдэнэ.
- 2.2.2 Эхлэх огноо** Үйлчилгээ үзүүлэгч нь тухайн үйлчилгээг гэрээ батлагдсан өдрөөс хойш эсхүл гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр үзүүлж эхэлнэ.
- 2.3 Дуусгахаар төлөвлөсөн өдөр** 2.6 дугаар зүйлд заасны дагуу хугацаанаас нь өмнө гэрээг цуцалснаас бусад тохиолдолд тухайн Үйлчилгээ үзүүлэгч нь үйл ажиллагаагаа ГТН-д тодорхойлсон дуусгахаар төлөвлөсөн өдөрт дуусгана.
- 2.4 Нэмэлт өөрчлөлт** Энэ гэрээний цар хүрээ, үнэтэй холбоотой болон бусад нөхцөл болзолд оруулах өөрчлөлт нь зөвхөн талуудын бичгээр үйлдсэн тохиролцоонд үндэслэх ба гэрээний санхүүжилтийг хариуцаж буй засгийн газрын холбогдох байгууллагын зөвшөөрөл авсанаар уг тохиролцоо нь хүчин төгөлдөр болно.

## **2.5 Форсе-Мажор**

Улс орныг хамарсан үймээн самуун, улс төрийн тогтворгүй байдал, байгалийн онц ноцтой гамшигт байдал гэх мэт гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс

### **2.5.1 Тодорхойлолт**

Энэ гэрээний зорилгын хүрээнд аль нэг талын боломжит хяналтаас гадуур давагдашгүй хүчний шинжтэй байдал бий болж энэ гэрээний дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх боломжгүйд хүрэх эсхүл тодорхой нөхцөл байдлыг улмаас боломжгүй гэж үзэж болохоор нөхцөл байдал үүссэнийг Форсе-Мажор гэж ойлгоно.

### **2.5.2 Гэрээг зөрчөөгүй гэж үзэх**

Форсе-Мажор нөхцөл байдлын улмаас гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй талыг дараах тохиолдолд энэ гэрээг зөрчсөн гэж үзэхгүй. Үүнд: Уг нөхцөл байдалд өртсөн тал нь а/ түүнээс урьдчилан сэргийлэх, санаа тавих, өөр хувилбар хайх зэргээр гэрээний нөхцөл болзлыг хангахын тулд болмжит бүх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн, б/ энэхүү нөхцөл байдал үүссэн талаар нөгөө талдаа аль болох урьдаас урьдчилан мэдэгдсэн байна.

### **2.5.3 Хугацаа сунгах**

Форсе-Мажор нөхцөлийн үүссэний улмаас гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу үйл ажиллагаагаа явуулах боломжгүй байсан тэр хугацаагаар уг талын гэрээ дуусгах хугацааг сунгана.

### **2.5.4 Төлбөр**

Шаардлагагүй.

## **2.6 Гэрээг цуцлах**

### **2.6.1 Захиалагч гэрээг цуцлах**

Захиалагч энэ 2.6.1. –д заасан аливаа нөхцөл байдал үүссэн тохиолдолд (30) –аас багагүй хоногийн өмнө гэрээг цуцлах тухай мэдэгдлийг бичгээр хүргүүлсний үндсэн дээр гэрээг цуцлаж болно:

- (а) Хэрэв үйлчилгээ үзүүлэгч нь Гэрээний дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх явцдаа гаргасан алдааг захиалагч илрүүлж түүнд мэдэгдсэнээс хойш 30 хоногийн хугацаанд эсхүл захиалагчийн бичгээр гаргасан мэдэгдэлд 30 хоногоос илүүгээр заасан хугацаанд багтаж залруулаагүй бол ;
- (б) Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон эсхүл дампуурсан бол;
- (в) Хэрэв форсе-мажор нөхцөлөөс үүдэн Үйлчилгээ үзүүлэгч нь тухайн үйлчилгээний үндсэн хэсгийг (60)-аас багагүй хоногийн дотор хийж гүйцэтгэх боломжгүй болсон; эсхүл
- (г) Хэрэв үйлчилгээ үзүүлэгч нь тухайн гэрээг хэрэгжүүлэх болон гэрээ байгуулах эрх олж авах явцдаа авилга, эсхүл залилан мэхлэх үйл ажиллагаанд холбогдсон нь шүүх эсхүл холбогдох байгууллагаар нотлогдсон бол.



- (д) Хэрэв захиалагч шаардлагатай гэж үзсэн тохиолдолд бие даан гэрээг цуцлах шийдвэр гаргаж болно.

**2.6.2**  
**Үйлчилгээ**  
**үзүүлэгч**  
**гэрээг**  
**цуцлах**

Үйлчилгээ үзүүлэгч нь 2.6.2. зүйлийн (а) –д заасан аливаа нөхцөл байдал үүссэн тохиолдолд (60)–аас багагүй хоногийн өмнө гэрээг цуцлах тухай мэдэгдлийг Захиалагчид бичгээр хүргүүлсний үндсэн дээр гэрээг цуцлаж болно:

- (а) Хэрэв Үйлчилгээ үзүүлэгч нь Форс-мажор нөхцөлийн улмаас (60)-аас багагүй хоногоор үндсэн үйлчилгээг гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд.

### **3. Үйлчилгээ үзүүлэгчийн эрх үүрэг**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Үйлчилгээ үзүүлэгч нь үйл ажиллагааны хуваарь болон техникийн тодорхойлолтод заасны дагуу үйлчилгээг үзүүлэхдээ нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн арга техник болон практик зарчмын дагуу өөрийн үүргийг хэмнэлттэй, үр ашигтай, чармайлт гарган гүйцэтгэх ба сайн удирдлага, зохион байгуулалттайгаар ажиллаж аюулгүй арга хэлбэр, тохиромжит дэвшилтэт технологийг ашиглана. Үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү гэрээний эсхүл үйлчилгээнд хамаарах үйл ажиллагаа явуулахдаа захиалагчид ямагт шударга зөвлөгөө өгөх бөгөөд туслан гүйцэтгэгч эсхүл гуравдагч этгээдтэй харилцах аливаа асуудалд хандахдаа ямагт захиалагчийн хууль ёсны эрх сонирхлыг хамгаалж, дэмжиж ажиллана.

Захиалагч нь гүйцэтгэгчийн үйл ажиллагаа түүний дүрэм журам болон энэ гэрээнд заасны дагуу явагдаж байгаа эсэх талаар дүгнэлт гарган, үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хянан, арга хэмжээ авч, шийдвэр гаргах эрхтэй.

#### **3.2 Сонирхлын зөрчилдөөн**

##### **3.2.1 Үйлчилгээ үзүүлэгч нь аливаа урамшуулал, хөнгөлөлтөөс ашиг хүртэхгүй байх.**

Үйлчилгээ үзүүлэгчид төлөх үйлчилгээний нийт хөлс нь зөвхөн энэ гэрээ буюу үйлчилгээтэй холбогдож төлөгдөх үйлчилгээ үзүүлсэний төлбөр байх бөгөөд Үйлчилгээ үзүүлэгч нь энэ гэрээний дагуу, эсхүл гэрээний үүргээ биелүүлэхэд хэрэгжүүлсэн аливаа үйл ажиллагаатай холбогдуулж өөрт ашигтайгаар урамшуулал, хөнгөлөлт, болон ижил төстэй төлбөрийг бусад этгээдээс Захиалагчаас өгсөн зөвшөөрлийн үндсэнд авч болно. Үйлчилгээ үзүүлэгч нь мөн өөрийн ажилтан болон туслан гүйцэтгэгчид, холбогдох бусад хамтрагчдыг дээрхтэй ижил төстэй нэмэлт хөлс авахгүй байх явдлыг хангахын төлөө ажиллана.

##### **3.2.2 Үйлчилгээ**

Үйлчилгээ үзүүлэгч болон түүний хамтрагч, түүнчлэн аливаа



**үзүүлэгч болон түүний хамтрагч нь төсөлд өөр сонирхолтойгоор оролцохгүй байх**

туслан гүйцэтгэгч болон түүний хамтрагч нь гэрээг хэрэгжүүлэх хугцаанд болон гэрээний хэрэгжилт дууссанаас хойш энэхүү үйлчилгээ болон үүнтэй нягт холбоотой бусад төслийн бараа, ажил, үйлчилгээ (энэхүү гэрээгээр үзүүлж байгаа үйлчилгээнээс бусад үйлчилгээ)-ний гүйцэтгэгч, нийлүүлэгч байх эрхгүй.

**3.2.3 Зөрчилтэй үйл ажиллагаанд оролцохыг хориглох**

Үйлчилгээ үзүүлэгч эсхүл түүний туслан гүйцэтгэгч эсхүл тэдгээрийн ажилтан дараах үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцохыг хориглоно. Үүнд:

- (a) Гэрээний хэрэгжилтийн хугацаанд гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу гүйцэтгэж буй үйл ажиллагаатай зөрчилдөх аливаа бизнесийн эсхүл мэргэжлийн үйл ажиллагаа явуулах;
- (b) Гэрээний хэрэгжилтийн хугацаанд үйлчилгээ үзүүлэгч эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн зүгээс төрийн албан хаагчийг гэрээний дагуу явуулах аливаа үйл ажиллагааг гүйцэтгэх үндсэн ажилтнаар хөлсөлж ажиллуулах;
- (c) Энэхүү гэрээ дууссанаас хойш гэрээний тусгай нөхцөлд заасан бусад үйл ажиллагаа явуулах.

**3.3 Нууцлал**

Үйлчилгээ үзүүлэгч, түүний туслан гүйцэтгэгч болон тэдгээрийн ажилтан нь тухайн гэрээ, төсөл, үйлчилгээ болон Захиалагчийн үйл ажиллагаатай холбоотой өмчлөлийн болон нууц мэдээллийг гэрээний хэрэгжилтийн явцад болон гэрээг хэрэгжүүлж дууссанаас хойш (2) жилийн хугацаанд захиалагчийн бичгээр урьдчилан өгсөн зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахыг хориглоно.

**3.4 Үйлчилгээ үзүүлэгчийн хариуцах даатгал**

Үйлчилгээ үзүүлэгч нь (a) ГТН-д заасан эрсдэлийн эсрэг захиалагчийн зөвшөөрсөн нөхцөлөөр өөрийн/ байгаа бол туслан гүйцэтгэгчийн зардлаар/ зардлаар даатгуулах бөгөөд (б) захиалагчийн хүсэлтээр даатгуулсан тухай болон даатгалын төлбөр хийсэн талаарх нотлох баримтыг захиалагчид хүргүүлж болно.

**3.5 Үйлчилгээ үзүүлэгч захиалагчаас**

Үйлчилгээ үзүүлэгч нь үйл ажиллагааны аль нэгийг явуулахын өмнө Захиалагчаас заавал бичгээр урьдчилан зөвшөөрөл авна. Үүнд:

- (a) Үйлчилгээний аль нэг хэсгийг туслан гүйцэтгүүлэх бол,



**урьдчилан зөвшөөрөл авах шаардлагатай үйл ажиллагаа** (б) Үйл ажиллагааны хөтөлбөрийг өөрчлөх,  
(г) ГТН-д дурдсан бусад арга хэмжээ авах.

**3.6 Тайлагнах үүрэг хариуцлага** Үйлчилгээ үзүүлэгч нь Хавсралт Б-д тодорхойлсон тайлан, баримт бичгүүдийг уг хавсралтад заасан хугацаанд, заасан маягтаар ирүүлнэ.

**3.7 Үйлчилгээ үзүүлэгчийн бэлтгэсэн баримт бичгүүд нь Захиалагчийн өмч байх** 3.6 дугаар зүйлийн дагуу үйлчилгээ үзүүлэгчийн ирүүлсэн бүх төлөвлөгөө, зураг, техникийн тодорхойлолт, загвар, тайлан бусад баримт бичиг болон программ хангамж нь үйлчлүүлэгчийн өмч болж үлдэх бөгөөд Үйлчилгээ үзүүлэгч нь эдгээрийг холбогдох бүртгэлийн хамт тухайн гэрээ дуусгавар болохоос эсхүл гэрээний хугацаа дуусахаас өмнө захиалагчид ирүүлэх үүрэгтэй. Үйлчилгээ үзүүлэгч нь эдгээр баримт бичиг болон програм хангамжийн хуулбарыг авч үлдэж болно. Гэхдээ авч үлдсэн тохиолдолд түүнийг ГТН-д заасан хязгаарлалтын хүрээнд цаашид ашиглаж болно.

**3.8 Үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээ ба техник хэрэгсэл** Үйлчилгээ үзүүлэгч нь Хавсралт Г-д дурдсан тоног төхөөрөмж болон үйлчилгээгээр хангах үүрэгтэй.

#### **4. Үйлчилгээ үзүүлэгчийн боловсон хүчин**

**4.1 Боловсон хүчний тодорхойлолт** Үйлчилгээ үзүүлэгчийн голлох боловсон хүчний албан тушаал, санал болгож буй ажлын байрны тодорхойлолт, чадварын доод шаардлагууд болон үйлчилгээг гүйцэтгэхэд ажиллуулахаар тооцсон хугацаа зэрэг нь Хавсралт В-д тодорхой тусгагдсан.

**4.2 Боловсон хүчнийг солих/ халах** (а) Хэрэв Үйлчилгээ үзүүлэгчээс хамаарахгүй шалтгаанаар голлох боловсон хүчин/ажилтныг солих шаардлага гарвал Үйлчилгээ үзүүлэгч нь түүнтэй ур чадвараараа дүйцэхүйц эсхүл түүнээс илүү чадвартай боловсон хүчнийг оронд нь ажиллуулахаар санал болгоно.

- (б) Хэрэв Үйлчилгээ үзүүлэгчийн боловсон хүчин нь (i) эрүүгийн гэмт хэрэгт холбогдсон болох нь тогтоогдсон, (ii) гэрээний дагуу гүйцэтгэж буй ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн зэргийг захиалагч мэдсэн бол эдгээр үндэслэлээр тухайн ажилтныг захиалагчийн хүлээн зөвшөөрөхүйц чадвар, туршлагатай өөр ажилтнаар солиулах хүсэлтийг Үйлчилгээ үзүүлэгчид бичгээр гаргана.
- (в) Боловсон хүчнийг халах эсхүл солих үйл явдалтай холбоотой гарах аливаа нэмэлт зардлыг Үйлчилгээ үзүүлэгч захиалагчаас нэхэмжлэх эрхгүй.

## 5. Захиалагчийн эрх үүрэг

### 5.1 Туслалцаа болон Хөнгөлөлт

Үйлчилгээ үзүүлэгчид ГТН-д заасан хөнгөлөлт, туслалцааг үзүүлэхэд шаардлагатай бүх талын арга хэмжээг захиалагч авч хэрэгжүүлнэ.

### 5.2 Гэрээний хуульд өөрчлөлт орох

Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш гэрээний хууль тогтоомжид өөрчлөлт орсны улмаас гэрээнд өөрчлөлт оруулж болно.

### 5.3 Үйлчилгээ ба техник хэрэгсэл

Захиалагч нь Үйлчилгээ үзүүлэгчийг тоног төхөөрөмж, техник хэрэгслэлээр хангах үүрэг хүлээхгүй.

## 6. Ажил-өдөр

### 6.1 Ажиллах өдрүүд

Үйлчилгээ үзүүлэгч ажил-өдрөөр тооцогдон төлөгдөх бүх ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн талаар захиалагчийн баталсан маягтын дагуу тэмдэглэл хөтөлнө. Бөглөсөн маягтыг ажил үйлчилгээг гүйцэтгэснээс хойш 2 хоногийн дотор багтааж захиалагчаар, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдээр батлуулна. /шаардлагагүй/

## 7. Чанарын хяналт

### 7.1 Зөрчил

Захиалагч Үйлчилгээ үзүүлэгчийн ажил, үйлчилгээний гүйцэтгэлийг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд



## **ГОЛОГДОЛ ИЛРҮҮЛЭХ**

мэдэгдэнэ. Ийнхүү шалгах нь Үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Захиалагч зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажил, үйлчилгээнд зөрчил, гологдол хайх, уг үйлчилгээний далд хэсгийг нээх, аль нэг үйлчилгээний туршилт хийхийг Үйлчилгээ үзүүлэгчээс шаардах эрхтэй. Чанарын баталгаат хугацааг ГТН-д тодорхойлсны дагуу байна.

### **7.2 Зөрчил, гологдол арилгах, Дутуу гүйцэтгэлд торгууль ногдуулах**

- (а) Захиалагч гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг Үйлчилгээ үзүүлэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
- (б) Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр Үйлчилгээ үзүүлэгч уг зөрчил, гологдлыг захиалагчийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- (в) Хэрэв үйлчилгээ үзүүлэгч нь Захиалагчийн мэдэгдэлд заасан хугацаанд гаргасан алдаа дутагдлыг арилгаагүй бол Захиалагч зөрчлийг арилгахад гарах зардлыг үнэлж дутуу гүйцэтгэсэн ажлын торгуулийг ногдуулах бөгөөд Үйлчилгээ үзүүлэгч уг торгуулийг захиалагчид төлөх үүрэгтэй.
- (г) Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээний 7.2-ын (а)-д заасан Мэдэгдлээр өгөгдсөн үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагчийн санаачлагаар тус гэрээг хэсэгчлэн болон бүхэлд нь хүчингүй болгох бүрэн эрхтэй.
- (д) Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээний хугацаанд захиалагчийн гүйцэтгэх ажлын даалгаврыг тус гэрээнд хавсаргаж, гарын үсэг зурж баталгаажуулна.

## **8. Маргааныг шийдвэрлэх**

### **8.1 Маргааныг шийдвэрлэх**

Талууд гэрээтэй холбоотой гарах аливаа маргааныг харилцан зөвшилцөж эв зүйгээр шийдвэрлэхийг хичээнэ. Хэрэв талууд тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлнэ.

## БҮЛЭГ 2. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- Гэрээний Ерөнхий нөхцөлийн холбогдох зүйлийн дугаар**
- Гэрээний ерөнхий нөхцөлийн зүйл, заалтад оруулсан нэмэлт, өөрчлөлт**
- 1.1(а) Гэрээний нэр нь **Нягтлан бодох бүртгэлийн төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэх**
- 1.1(б) Захиалагч нь Сангийн яам .
- 1.1(в) Төлөөлөх эрх бүхий нэгж нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар.
- 1.1(г) Үйлчилгээ үзүүлэгч нь Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн.
- 1.2 Гэрээний хууль нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль.
- 1.3 Гэрээний хэл - *Монгол*
- 1.4 Хаяг:  
Захиалагч: *Монгол Улсын Сангийн яам, С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр, Д корпус,*  
Хэнд: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар  
Утас: 51-263069  
Факс:
- Үйлчилгээ үзүүлэгч: *Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн*  
*Хаяг: Улаанбаатар 14200, Сүхбаатар дүүрэг, Сүхбаатарын талбай, Тусгаар тогтнолын ордон. Зүүн жисгүүр 707 тоот*
- Хэнд: Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн  
Утас: 77070880, 99112647, 99092301 Факс: 976-11-77070880  
И-майл: [info@mains.mn](mailto:info@mains.mn)
- 1.6 Төлөөлөх эрх бүхий этгээдүүд:  
Захиалагчийг төлөөлөх: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга Б.Доржсэмбэд
- Үйлчилгээ үзүүлэгчийг төлөөлөх: Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнгийн тэргүүн Л.Дондог
- 2.1 Энэхүү гэрээ нь *2016 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс* эхлэн хүчин төгөлдөр болно.
- 2.2 Үйлчилгээг *2016 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс* эхлүүлнэ.
- 2.3 Дуусгахаар төлөвлөсөн өдөр нь *2017 оны 12 дугаар сарын 31-ны өдөр* байна.
- 3.1 3.1 Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 165 дугаар тогтоол болон энэхүү гэрээний дагуу Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1. мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийг





боловсруулан батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

3.1.2. аж ахуйн нэгж, байгууллагуудад хэрэглэгдэж байгаа нягтлан бодох бүртгэл хөтлөх програм хангамж нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Монгол Улсын холбогдох заавар журамд нийцсэн эсэх талаарх мэдээллээр хангах;

3.1.3. нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн програм хангамжид хяналт тавих;

3.1.4. Санхүүгийн тайлагналын болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын нэвтрэлт, мэргэжлийн нягтлан бодогчдын ажил эрхлэлтийн байдал, нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн хэрэглээний чиглэлээр зөвлөмж боловсруулах, судалгааны ажил хэрэгжүүлэх.

3.1.5. ажил эрхэлж байгаа мэргэжлийн нягтлан бодогчдын бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх.

3.1.6 Дүрэм болон дотоод журмын дагуу үйл ажиллагааны ил тод байдлыг ханган, эрх бүхий албан тушаалтан болон ажилтныг сонгон шалгаруулах болон сонирхлын зөрчлөөс сэргийлэх зарчмыг баримтлан ажиллах.

3.1.7 Энэ гэрээний дагуу гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлтийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтмол хүргэж байх

3.1.8 Гэрээ гүйцэтгэгч нь өөрийгөө санхүүжүүлэх зарчмын дагуу үйл ажиллагаа явуулах бөгөөд иргэний хувьд төлөх хураамжийн хэмжээг Захиалагч болон Үйлчилгээ үзүүлэгч тухай бүр харилцан тохиролцож байх;

3.1.9. Гэрээ гүйцэтгэгч нь гэрээний 3.1.8-д зааснаас бусад аливаа төлбөр хураамж татвар зэргийг гишүүд болон хуулийн этгээдээс авахгүй байх.

Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйтэй холбогдож захиалагчид болон бусад гуравдагч этгээдэд хохирол учирсан бол хохиролыг холбогдох хуульд заасан журмаар барагдуулна.

3.2

**СЯ1609 ТООТ ГЭРЭЭНИЙ  
ХАВСРАЛТ**

**Хавсралт А—Үйлчилгээний тодорхойлолт болон хуваарь**

Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үндэслэн энэхүү гэрээний ерөнхий болон тусгай нөхцлийн хүрээнд дараах үйл ажиллагааг гүйцэтгэнэ. Үүнд:

**Үйлчилгээний үр дүнгийн тодорхойлолт**

<i>Үйлчилгээ</i>	<i>Үйлчилгээний төрөл</i>	<i>Үр дүн, чанар</i>
Үйлчилгээ 1	Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийг боловсруулан батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;	НБОУХ-ноос батлан гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн стандартын агуулгад нийцүүлэн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийг боловсруулж батлах, цаашид боловсронгуй болгох. Мэргэжлээрээ ажиллаж байгаа нягтлан бодогчод ёс зүйн дүрмийг тайлбарлан таниулах, хүлээн зөвшөөрүүлэх ажил зохион байгуулах, тэдний ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн байдалд хяналт тавих
Үйлчилгээ 2	Аж ахуйн нэгж, байгууллагуудад хэрэглэгдэж байгаа нягтлан бодох бүртгэл хөтлөх програм хангамж нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Монгол Улсын холбогдох заавар журамд нийцсэн эсэх талаарх мэдээллээр хангах;  Нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн програм хангамжид хяналт тавих;	Аж ахуйн нэгж байгууллагад ашиглагдаж байгаа НББ-ийн програм хангамжийн талаар судалгаа хийх.  Ашиглагдаж байгаа програм хангамж нь СТОУС, УСНББОУС болон Монгол улсын хууль тогтоомжид нийцэж байгаа талаар мэдээлэл бэлтгэх. НББ-ийн зөвшөөрөгдсөн програм хангамжийн хэрэглээ, боловсруулалтын байдалд хяналт тавих, програмын чанар, үр дүнгийн талаар боловсруулагчидтай хамтран ажиллах.
Үйлчилгээ 3	Санхүүгийн тайлагналын болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын нэвтрэлт, мэргэжлийн нягтлан бодогчдын ажил эрхлэлтийн байдал,	Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын нэвтрэлтийн талаар судалгаа хийх, зөвлөмж боловсруулах. Мэргэжлийн нягтлан бодогчдын ажил эрхлэлтийн байдлын талаар судалгаа хийх, зөвлөмж боловсруулах.





	нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн хэрэглээний чиглэлээр зөвлөмж боловсруулах, судалгааны ажил хэрэгжүүлэх.	Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн хэрэглээний талаар судалгаа хийх, зөвлөмж боловсруулах.
Үйлчилгээ 4	Ажил эрхэлж байгаа мэргэжлийн нягтлан бодогчдын бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх.	Мэргэжлээрээ ажиллаж байгаа нягтлан бодогчдын бүртгэл хөтлөх, мэдээллийн сан байгуулах, хэрэглэгчдэд мэдээлэх.

Энэхүү гэрээнд заасны дагуу Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн нь дараах хуваарийн дагуу үйл ажиллагаагаа гүйцэтгэнэ. Үүнд:

#### 2016-2017 оны Үйл ажиллагааны хуваарь

<i>Үйл ажиллагааны нэр төрөл</i>	<i>Хугацаа</i>	<i>Тайлбар</i>
Үйл ажиллагааны урьдчилсан тайлан, дараа оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийн хамт	Тухайн оны 12 сарын 15 дотор	Хавсралт Б-д заасан
Удирдах зөвлөлөөр хэлэлцэн баталсан жилийн эцсийн санхүүгийн тайланг үйл ажиллагааны тайлангийн хамт	Дараа оны 2 сарын 1 дотор	Хавсралт Б-д заасан
НБОУХ-ноос батлан гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн стандартын агуулгад нийцүүлэн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийг боловсруулж батлах, цаашид боловсронгуй болгох. Мэргэжлээрээ ажиллаж байгаа нягтлан бодогчод ёс зүйн дүрмийг тайлбарлан таниулах, хүлээн зөвшөөрүүлэх ажил зохион байгуулах, тэдний ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн байдалд хяналт тавих	Жилийн хугацаанд	Улаанбаатар хот болон орон нутагт зохион байгуулагдах
Аж ахуйн нэгж байгууллагад ашиглагдаж байгаа НББ-ийн програм хангамжийн талаар судалгаа хийх.	Жилийн хугацаанд	Улаанбаатар хот болон орон нутагт зохион байгуулагдах
Ашиглагдаж байгаа програм хангамж нь СТОУС, УСНББОУС болон Монгол улсын хууль тогтоомжид нийцэж байгаа талаар мэдээлэл бэлтгэх. НББ-ийн зөвшөөрөгдсөн програм		

хангамжийн хэрэглээ, боловсруулалтын байдалд хяналт тавих, програмын чанар, үр дүнгийн талаар боловсруулагчидтай хамтран ажиллах.		
Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын нэвтрэлтийн талаар судалгаа хийх, зөвлөмж боловсруулах. Мэргэжлийн нягтлан бодогчдын ажил эрхлэлтийн байдлын талаар судалгаа хийх, зөвлөмж боловсруулах. Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн хэрэглээний талаар судалгаа хийх, зөвлөмж боловсруулах	2016 оны 11 болон 12 сар. 2017 он	Улаанбаатар хот болон орон нутагт зохион байгуулагдах
Мэргэжлээрээ ажиллаж байгаа нягтлан бодогчдын бүртгэл хөтлөх, мэдээлэлийн сан байгуулах, хэрэглэгчдэд мэдээлэх	Жилийн хугацаанд	Улаанбаатар хот болон орон нутагт зохион байгуулагдах

Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн нь дүрмийн дагуу үйл ажиллагааны ил тод байдлыг ханган, эрх бүхий албан тушаалтан, ажилтныг сонгон шалгаруулах болон сонирхлын зөрчлөөс сэргийлэх зарчмыг баримтлан ажиллана.

#### **Хавсралт Б— Тайлагнах үүрэг хариуцлага**

Үйлчилгээ үзүүлэгч нь тухайн жилийн үйл ажиллагааны тайланг /урьдчилсан байдлаар/ дараа оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийн хамт тухайн оны 12 дугаар сарын 15-ний дотор; Удирдах зөвлөлөөр хэлэлцэн баталсан жилийн эцсийн санхүүгийн тайланг үйл ажиллагааны тайлангийн хамт дараа оны 2 дугаар сарын 01-ны дотор тус тус Захиалагч талд ирүүлнэ.





**Хавсралт В—Үйлчилгээ үзүүлэгчийн голлох боловсон хүчин**

*В-1 Албан тушаал, ажлын дэлгэрэнгүй тодорхойлолт болон тухайн ажилтанд тавигдах хамгийн бага чадварын шаардлага.*

<i>Албан тушаал</i>	<i>Тавигдах шаардлага</i>	<i>Чухал шаардлага</i>	<i>Ур чадвар</i>
<b>Ажлын алба:</b>			
Тэргүүн	Дээд боловсролтой, эрдмийн зэрэгтэй	Баг бүрдүүлэн бусдыг манлайлдаг, удирдах ажлын туршлагатай байх	Нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр туршлагатай, Судалгаа хийх, удирдах, Эрдэм шинжилгээний бүтээл гаргах, аргачлал, заавар, зөвлөмж боловсруулах чадвартай
Гүйцэтгэх захирал	Дээд боловсролтой, гадаад хэлний мэдлэгтэй	Харилцааны ур чадвартай, нууц хадгалах, манлайлагч	Баг бүрдүүлэн ажиллах, эрх мэдлийнхээ хүрээнд бусдад нөлөөлөх, бусдад урам хайрлах чадвартай, аргачлал, заавар, зөвлөмж боловсруулах чадвартай
Ерөнхий менежер	Дээд боловсролтой	Харилцааны ур чадвартай, манлайлагч, багаар ажиллах, баг удирдах чадвартай	Бусдад нөлөөлөх, бусдад урам хайрлах, баг бүрдүүлэн ажиллах. Эрх мэдлийн хүрээнд шийдвэр гаргадаг, аргачлал, заавар, зөвлөмж боловсруулах чадвартай
Сургалтын менежер	Дээд боловсролын магистраас доошгүй зэрэгтэй байх	Бусдыг манлайлах, компьютерийн өргөн хэрэглээний программууд дээр ажилладаг байх, илүү цагаар ажиллах, нууц хадгалах	Сургалтын хуваарь гаргах, сургалтад хичээл заах багш нарыг бэлтгүүлэх, багаар ажиллах чадвартай, санаачлагатай байх аргачлал, заавар, зөвлөмж боловсруулах чадвартай,
Нягтлан бодогч	Дээд боловсролын магистраас доошгүй зэрэгтэй байх	Компьютерийн өргөн хэргэлээний программууд дээр ажилладаг байх, илүү цагаар ажиллах, нууц хадгалах	Багаар ажиллах чадвартай, санаачлагатай байх, мэргэжлийн хичээл заах, аргачлал, заавар, зөвлөмж боловсруулах чадвартай
Мэдээлэл технологийн инженер	Дээд боловсролтой	Мэдээлэл технологийн болон компьютерийн эх бэлтгэлээр мэргэшсэн	Багаар ажиллах чадвартай, бүтээлч, аргачлал, заавар, зөвлөмж боловсруулах чадвартай
Гадаад харилцааны менежер	Дээд боловсролтой	Англи хэлний бичгийн болон ярианы өндөр мэдлэгтэй	Удирдан манлайлагч, багаар ажиллах чадвартай, бүтээлч

			санаачлагатай байх
Судалгааны ажилтан	Дээд боловсролтой	Эрдэм шинжилгээний бүтээл, судалгаа хийдэг байх, гадаад хэлний зохих мэдлэгтэй	Бүтээлч санаачлагатай, дүгнэлт харьцуулалт хийдэг, бусдыг удирдаж багаар ажиллах чадвартай байх, аргачлал, заавар, зөвлөмж боловсруулах чадвартай
Багш	Дээд боловсролын магистраас доошгүй зэрэгтэй байх	Нягтлан бодох бүртгэл, Гааль-Татвар, Нийгмийн даатгал, Хуулийн чиглэлээр 3-с дээш жил ажилласан мэргэжлийн дадлага туршлагатай, багшлах эрхтэй байх	Бүтээлч, санаачлагатай, өөрийгөө хөгжүүлж, тогтвор суурьшилтай ажиллах, аргачлал, заавар, зөвлөмж боловсруулах чадвартай

*В-2 Голлох мэргэжилтнүүдэд тавигдах шаардлага*

<i>Албан тушаал</i>	<i>Тавигдах шаардлага</i>
Удирдах Зөвлөл	Үүсгэн байгуулагчдын хурлаар Удирдах зөвлөлд сонгогдсон байх, Удирдах ажлын туршлага, багаар ажиллах, манлайлах,
Ажлын албадын дарга нар	Удирдан зохион байгуулан баг бүрдүүлж, манлайлан ажиллах чадвартай,

**Хавсралт Г— Үйлчилгээ үзүүлэгчийн үзүүлэх үйлчилгээ болон техник хэрэгсэл**

<i>Үйлчилгээ</i>	<i>Үйлчилгээний төрөл</i>	<i>Техник хэрэгсэл</i>
Үйлчилгээ 1	Мэргэжлээрээ ажиллаж байгаа нягтлан бодогчод ёс зүйн дүрмийг тайлбарлан таниулах, хүлээн зөвшөөрүүлэх ажил зохион байгуулах, тэдний ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн байдалд хяналт тавих	<ol style="list-style-type: none"> <li>1. Сургалтын анги танхим</li> <li>2. Гарын авлага ном сурах бичиг</li> <li>3. Техник тоног төхөөрөмж, компьютер, програм хангамж</li> </ol>
Үйлчилгээ 2	Аж ахуйн нэгж байгууллагад ашиглагдаж байгаа НББ-ийн програм хангамжийн талаар судалгаа хийх.  Ашиглагдаж байгаа програм хангамж нь СТОУС, УСНББОУС болон Монгол улсын хууль тогтоомжид нийцэж байгаа талаар мэдээлэл бэлтгэх. НББ-ийн зөвшөөрөгдсөн програм хангамжийн хэрэглээ, боловсруулалтын байдалд хяналт тавих, програмын чанар, үр дүнгийн талаар боловсруулагчидтай хамтран ажиллах.	



<p>Үйлчилгээ 3</p>	<p>Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын нэвтрэлтийн талаар судалгаа хийх, зөвлөмж боловсруулах, сургалт зохион байгуулах  Мэргэжлийн нягтлан бодогчдын ажил эрхлэлтийн байдлын талаар судалгаа хийх, зөвлөмж боловсруулах, мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах.  Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн хэрэглээний талаар судалгаа хийх, зөвлөмж боловсруулах, сургалт явуулах.</p>	
<p>Үйлчилгээ 4</p>	<p>Мэргэжлээрээ ажиллаж байгаа нягтлан бодогчдын бүртгэл хөтлөх, мэдээлэлийн сан байгуулах, хэрэглэгчдэд мэдээлэх, ажилд зуучлах.</p>	



ХААЦАА? ХЭЖЭ-?

ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйл, Засгийн газрын 2016 оны 165-р тогтоолыг үндэслэн нягтлан бодох бүртгэлийн төрийн зарим чиг, үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх гэрээний төслийг хүргүүлж байна.

САЙД



Б.ЧОЙЖИЛСҮРЭН

Хянасан:

Дэд сайд



Х.Булгантуяа

ТНБД

Б.Нямаа

29/8/2016.


ХХААБГ-ын дарга

Э.Хангай

НБББГ-ын дарга

Б.Доржсэмбэд

Боловруулсан:



9.2016.

НБББГ-ын ахлах мэргэжилтэн

Б.Болормаа

9/8



**ТАНИЛЦУУЛГА**

16.11.08

**Хэнд:** Сангийн сайд Б.Чойжилсүрэн, ТНБД Б.Нямаа танаа  
**Хаанаас:** Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга /.....  
**Утга:** СЯ-1609 тоот “Нягтлан бодох бүртгэлийн төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтын үр дүн  
**Хуудасны тоо:** 1  
**Боловеруулсан:** ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО

- |                                    |                          |   |                          |
|------------------------------------|--------------------------|---|--------------------------|
| - Албан хэрэгцээнд ашиглах         | <input type="checkbox"/> | - Нэгжийн удирдлагуудад танилцуулах     | <input type="checkbox"/> |
| - Веб сайтад байршуулах            | <input type="checkbox"/> | - Газруудаас санал авах                 | <input type="checkbox"/> |
| - Яамны нийт ажилтан нарт мэдээлэх | <input type="checkbox"/> | - Хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх | <input type="checkbox"/> |

Удирдлагаас .....  
өгсөн чиглэл: .....

Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 26.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай” Засгийн газрын 2016 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 165 дугаар тогтоолыг батлуулсан.

Дээрх хуулийн заалт болон ЗГ-ын тогтоолын дагуу яамнаас СЯ-1609 тоот “Нягтлан бодох бүртгэлийн төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах” зөвлөхөөс бусад үйлчилгээний харьцуулалтын тендерийг зарлан яамны болон худалдан авах ажиллагааны вэб сайтад байршуулан хэвлэл мэдээллээр олон нийтэд мэдээлсэн болно.

Тендерийн жишиг баримт бичигт тусгаснаар 2016 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 12:00 минутад тендерийг ажлын хэсгийн гишүүд болон байгууллагуудын төлөөллийг оролцуулан тендерийн бичиг баримтыг нээсэн. Уг тендерт Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн, Олон нийтийн боловсрол судалгааны төв гэсэн 2 байгууллага материалаа ирүүлсэн болно.

Олон нийтийн боловсрол судалгааны төв гэсэн ТТБ-ын ирүүлсэн тендер нь тендерийн баримт бичгийн тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны ТШӨХ-ийн 4.2к, 4.2з, 4.2и, 4.2й -д заасан шаардлагыг хангаагүй байна.

Иймд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн харьцуулалтын аргын дагуу Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн ТТБ-ын ирүүлсэн материал нь техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангаж байгаа тул, гэрээ хийх зөвшөөрөл олгоно уу.

**НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ГАЗАР**

**НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТӨРИЙН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ  
ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ СЯ 1609 ТООТ  
ГЭРЭЭНИЙ СУНГАЛТ**

2017 оны 12 –р сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Монгол Улсын Сангийн Яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар, Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнгийн хооронд 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр байгуулсан “Нягтлан бодох бүртгэлийн төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах” СЯ 1609 тоот дугаартай гэрээний хүчин төгөлдөр хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан Сангийн Яамны 2017 оны 12-р сарын 15-ны өдрийн гэрээ дүгнэсэн актыг үндэслэн гэрээний хүчин төгөлдөр үйлчлэх хугацааг 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хүртэл гурван жилийн хугацаатайгаар сунгав.
- 1.2 Захиалагч ба гүйцэтгэгч талуудын 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр байгуулсан СЯ 1609 тоот гэрээ, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, гэрээний хавсралтад заасан чиг үүргийг хэрэгжүүлэхдээ энэхүү гэрээний сунгалтын 1 дүгээр хавсралтаар баталсан маягтын дагуу жил бүрийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор гэрээг дүгнэсэн тэмдэглэлийг үйлдэж, гэрээг жил бүр дүгнэнэ.
- 1.3 Гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд 1 хувийг Сангийн яамны НБББГ, 1 хувийг Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнд тус тус хадгална.
- 1.4 Гэрээнд тамга дарж, гарын үсэг зурснаар энэ гэрээ хүчин төгөлдөр болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалагч:

САНГИЙН САЙД:



Гүйцэтгэгч:

МОНГОЛЫН НЯГТЛАН БОДОХ  
БҮРТГЭЛИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ТЭРГҮҮН





СЯ-ны НБББГ-ын дарга:




-----  
/Г.Түвдэндорж/

Монголын нягтлан бодох бүртгэлийн  
хүрээлэнгийн Ерөнхий менежер:



-----  
/Х.Дэлгэрсайхан/

СЯ-ны НБББГ-ын ахлах мэргэжилтэн:



-----  
/Б.Болормаа/

СЯ 1609 тоот гэрээний сунгалтын 1 дүгээр хавсралт

СЯ 1609 ТООТ ГЭРЭЭГ ДҮГНЭСЭН ТЭМДЭГЛЭЛ

Гэрээний нэр	Татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээний төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэх
Гэрээний дугаар:	СЯ 1609
Гэрээ сунгасан огноо:	2017 оны 12 дугаар сарын 15
Гэрээ дүгнэсэн огноо:	2018 оны 12 дугаар сарын 15
Гэрээний биелэлт:	
Шийдвэр:	

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН:

Захиалагч:  
САНГИЙН САЙД:

-----  
/ Ч.ХҮРЭЛБААТАР /

Төрийн нарийн бичгийн даргын үүргийг хариуцагч, Төрийн сангийн газрын дарга:

-----  
/С.Наранцогт/

СЯ-ны НБББГ-ын дарга:

-----  
/ Г.Түвдэндорж/

СЯ-ны НБББГ-ын ахлах мэргэжилтэн:

-----  
/Б.Болормаа/

Гүйцэтгэгч:  
МОНГОЛЫН НЯГТЛАН БОДОХ  
БҮРТГЭЛИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ТЭРГҮҮН

-----  
/ Л.ДОНДОГ /

Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнгийн Ерөнхий менежер:

-----  
/Х.Дэлгэрсайхан/



## 2018 оны үйл ажиллагааны хуваарь

№	Хэрэгжүүлэх ажил	Хугацаа	Хариуцах байгууллага
	Нэг. НББ-ийн программын талаар		
1.1	“Аж ахуйн нэгж байгууллагад ашиглагдаж байгаа нягтлан бодох бүртгэлийн программ нь СТОУС-т нийцсэн байдалд хяналт тавих журам”-ыг хэрэгжүүлэх, аргачлалыг боловсруулж батлах	1 сараас	МНББХ
1.2	Бизнесийн байгууллагад ашиглагдаж байгаа нягтлан бодох бүртгэлийн программ нь СТОУС-т нийцсэн байдлыг үнэлэх тест боловсруулах	1 сараас	МНББХ
1.3	НББ-ийн программд үнэлэлт өгөх ажлын хэсгүүдийг байгуулах	1 сар	МНББХ
1.4	НББ-ийн программд үнэлэлт өгөх, мэдээлэх ажлыг зохион байгуулах	1-ээс 12 сар	МНББХ
1.5	НББ-ийн программ зохиогчдод мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх	1-ээс 12 сар	МНББХ
1.6	СЯ 1609 тоот гэрээний тусгай нөхцлийн 3.1.8-ийн дагуу НББ-ийн программ нь СТОУС-т нийцсэн байдалд үнэлэлт өгөх ажиллагааны төлөө аж ахуйн нэгжээс авах төлбөрийн хэмжээг тохиролцох	1 дүгээр сар	СЯ, МНББХ
	Хоёр. Судалгаа шинжилгээ хийх, зөвлөмж боловсруулах талаар		
2.1	“Нягтлан бодох бүртгэлийг 2018-2020 онд хөгжүүлэх Засгийн газрын хөтөлбөр”-ийн төслийг эцэслэн боловсруулах, батлуулах талаар Сангийн яаманд дэмжлэг үзүүлж ажиллах	1-ээс 4 дүгээр сар	СЯ, МНББХ
2.2	Нягтлан бодох бүртгэлийн маягтуудыг шинэчлэх, дансны төлөвлөгөө, код, нэр томъёог нэг мөр болгох асуудлаар Сангийн яаманд асуудал оруулж шийдвэрлүүлэх	1-ээс 3 сар	СЯ, МНББХ
	Гурав. Мэргэжлийн нягтлан бодлогчдыг бүртгэл, Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн талаар		
3.1	Ажиллаж байгаа мэргэжлийн нягтлан бодогчдыг бүртгэх	Жилийн турш	МНББХ

3.2	Нягтлан бодогчдын бүртгэл, хайлт хийх, мэдээлэл хүргэх, ёс зүйн хяналт тавих программ хангамжтай болох	1-р улиралд	МНББХ
3.3	Гишүүдээс ёс зүйн тайлан авах, нэгтгэх, мэдээлэх журам боловсруулж, батлан, хэрэгжүүлэх	2-р улиралд	МНББХ
3.4	Мэргэжлийн нягтлан бодогчдын бүртгэл, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн явцын талаар тайлан, мэдээлэлээр Сангийн яамыг хангаж, холбогдох арга хэмжээг тухай бүр хэрэгжүүлж ажиллах	Жилийн турш	СЯ, МНББХ

Баталсан: СЯ-ны НБББГ-ын дарга



/Г.Түвдэндорж/

Хянасан: МНББХ-ийн тэргүүн



/Л.Дондог/

Боловсруулсан: МНББХ-ийн Ерөнхий менежер



/Х.Дэлгэрсайхан/